



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2017 оны 07 сарын 18 өдөр

Дугаар Я/78


Улаанбаатар хот

**Тушаалд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтооолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны “Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” А/53 дугаар тушаалын хавсралт дахь Лхагвадоржийн Мөнхзаяад холбогдох хэсгийн “1 жил” гэснийг “2 жил” гэж, 2015 оны А/155 дугаар тушаалын хавсралт дахь Наянтайгийн Цолмонд холбогдох хэсгийн “2.5 жил” гэснийг “3 жил” гэж, 2016 оны А/112 дугаар тушаалын хавсралт дахь Шагдарын Туяад холбогдох хэсгийн “магистр” гэснийг “доктор”, “1 жил” гэснийг “2 жил” гэж тус тус өөрчилсүгэй.
2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Э.Энх-Амгалан/-т тус тус даалгасугай.

САЙД



Г.ЧУЛУУНБААТАР